



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгино сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/018/НА-СТА-ТТЗ

Цахим хүүдас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Улиастай сум 2024 он	Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
	Аудитор: О.Алтансүвд Утас: 88009224 Цахим хаяг: altansuvdo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.08.24 № 369

талаа _____ -ны № _____ -г

СОНГИНО СУМЫН
ЗАСАГ ДАРГА С.ГАНЗОРИГ-Т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сонгино сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Сонгино сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Засаг даргын нөөц сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон эрх шилжсэн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 129,350.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сонгино сумын Засаг дарга нь тайлант онд 241,438.3 мянган төгрөгийн

хөрөнгө худалдан авч, 290,127.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 5,267.9 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр ахталж, 245.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийг гэрээний хугацаанд эргэн төлүүлээгүйтэй холбоотой 47,756.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь шинж чанарын хувьд материаллаг байна. Энэхүү зөрчлийг аудитын дүгнэлтэд хамааруулаагүй болно.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		969,705.6	1,037,280.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	669,809.6	738,960.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	130,734.4	105,368.1
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	169,161.4	192,952.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		967,563.8	1,350,402.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	967,563.8	1,350,402.4
39200	Биет хөрөнгө		952,701.8	1,322,002.4
39300	Биет бус хөрөнгө	13	14,862.0	28,400.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,937,269.3	2,387,683.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,488.2	7,000.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	9,488.2	7,000.0
41300	Өглөг	17а, 17б	9,488.2	7,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,927,781.1	2,380,683.2
51	Засгийн газрын хувь оролцоо		1,927,781.1	2,380,683.2
51100	Засгийн газрын оруулсан капитал		390,906.3	390,906.3
51200	Хуримтлагдсан үр дүн		1,251,841.0	1,704,743.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		285,033.9	285,033.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,937,269.3	2,387,683.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,134,421.6	2,757,038.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		527,000.8	700,081.1
110	Орлогын албан татвар		303,385.9	435,316.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		314,715.1	454,999.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-11,329.3	-19,682.9
113	Хөрөнгийн албан татвар		18,562.5	47,282.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		205,052.4	217,482.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	434,651.5	700,713.2
120	Нийтлэг татварын бус орлого		434,651.5	700,713.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,172,769.2	1,356,244.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,525,770.9	1,982,846.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,525,770.9	1,982,846.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,165,380.9	1,741,361.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		401,879.3	565,165.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		46,731.4	67,395.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		67,988.2	578,540.8
2104	Хангамж, бараа материалын зардал		61,701.9	29,047.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,010.0	31,542.8
2107	Томиллолт, зочны зардал		7,831.5	12,042.9

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,104.0	4,831.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		576,134.7	452,795.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,360,390.0	241,485.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		608,650.7	774,192.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		450,623.7	321,290.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		158,026.9	452,902.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,906.26	285,033.86	1,093,814.07	1,769,754.18
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,906.26	285,033.86	1,093,814.07	1,769,754.18
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	158,026.94	158,026.94
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,906.26	285,033.86	1,251,841.00	1,927,781.12
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	390,906.26	285,033.86	1,251,841.00	1,927,781.12
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,906.26	285,033.86	1,251,841.00	1,927,781.12
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	452,902.03	452,902.03
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	390,906.26	285,033.86	1,704,743.04	2,380,683.15

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,808,258.77	2,185,803.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	527,000.80	700,081.06
110	Орлогын албан татвар	303,385.87	435,316.19
1100	Хувь хүний орлогын албан татвар	314,715.13	454,999.11
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	231,877.73	341,743.99
110002	Үйл ажиллагааны орлого	82,837.41	65,942.50
110008	Шууд бус орлого	0.00	47,312.62
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-11,329.27	-19,682.92
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-11,329.27	-19,682.92
113	Хөрөнгийн албан татвар	18,562.50	47,281.99
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10,352.60	13,914.39
113002	Бууны албан татвар	2,242.40	3,756.00
113004	Малд ногдуулах албан татвар	5,967.50	29,611.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	205,052.43	217,482.88
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,170.60	16,710.80

118001	Улсын тэмдэгтийн хураамж	819.30	13,540.80
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	111.30	0.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	240.00	3,170.00
1181	Газрын төлбөр	11,317.26	6,965.17
118101	Газрын төлбөр	1,817.78	6,965.17
118102	Дуудлага худалдаа	9,499.48	0.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	192,564.57	193,806.92
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	3,742.57	5,036.92
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	188,820.00	187,920.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.00	650.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.00	200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,488.73	129,477.45
120	Нийтлэг татварын бус орлого	108,488.73	129,477.45
120002	Хүүгийн орлого	37,025.17	41,901.49
120003	Торгуулийн орлого	44,298.50	61,845.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,597.47	25,346.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,597.47	25,346.87
120009	Бусад орлого	567.60	383.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,172,769.24	1,356,244.53
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,370.04	50,582.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	34,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,370.04	15,982.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,130,399.20	1,305,661.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,465,160.80	511,317.40
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	395,639.30	500,756.90
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	229,362.80	293,587.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,428,092.44	1,780,273.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,428,092.44	1,780,273.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,067,702.46	1,538,787.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	401,778.78	565,165.08
210101	Үндсэн цалин	273,482.99	370,970.16
210102	Нэмэгдэл	94,658.22	180,811.21
210104	Урамшуулал	33,637.58	13,383.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,731.38	67,375.57
210201	Тэтгэврийн даатгал	31,866.86	46,036.75
210202	Тэтгэмжийн даатгал	3,748.19	5,511.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,015.61	3,001.48
210204	Ажилгүйдлийн даатгал	747.43	2,346.74
210205	Эрүүл мэндийн даатгал	7,353.30	10,478.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,988.19	588,029.02
210301	Гэрэл, цахилгаан	4,568.19	33,980.79
210302	Түлш, халаалт	63,420.00	551,573.32
210303	Цэвэр, бохир ус	0.00	2,474.90
2104	Хангамж, бараа материалын зардал	18,926.59	22,431.85
210401	Бичиг хэрэг	3,312.20	3,822.16
210402	Тээвэр, шатахуун	12,647.79	15,525.37
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,966.60	3,084.33

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200.00	31,452.83
210604	Урсгал засвар	1,200.00	31,452.83
2107	Томилолт, зочны зардал	6,005.30	5,042.90
210702	Дотоод албан томилолт	6,005.30	5,042.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,492.44	5,201.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,719.06	4,125.25
210803	Даатгалын үйлчилгээ	333.63	459.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.66	217.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	203.00
210807	Газрын төлбөр	138.30	123.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	521,579.77	254,088.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	519,161.77	250,310.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,418.00	3,778.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,360,389.98	241,485.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	150,000.00	148,395.67
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	150,000.00	148,395.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,478.60	83,187.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	48,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,478.60	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	34,287.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,187,911.38	9,902.82
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,127,331.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,797.69	2,876.04
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,782.70	7,026.78
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	380,166.33	405,529.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	534,425.76	335,790.21
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	534,425.76	335,790.21
2200	Дотоод эх үүсвэрээр	534,425.76	335,790.21
223001	Бусад хөрөнгө	448,738.76	321,290.21
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,687.00	14,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-534,425.76	-335,790.21
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-68,491.40	-589.20
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	68,491.40	589.20
230001	Эргэж төлөгдөх зээл	68,491.40	589.20
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-222,750.83	69,150.49
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	892,560.48	669,809.65
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	669,809.65	738,960.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,128,638.50	1,914,798.12

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,690,645.00	1,592,918.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,607,458.00	1,509,731.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	627,678.30	561,417.08
210101	Үндсэн цалин	448,464.50	367,222.16
210102	Нэмэгдэл	179,213.80	180,811.21
210104	Урамшуулал	0.00	13,383.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,897.20	67,375.57
210201	Тэтгэврийн даатгал	53,650.10	46,036.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,311.70	5,511.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,574.60	3,001.48
210204	Ажилгүйдлийн даатгал	2,737.20	2,346.74
210205	Эрүүл мэндийн даатгал	12,623.60	10,478.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	592,397.40	588,029.02
210301	Гэрэл, цахилгаан	44,091.10	33,980.79
210302	Түлш, халаалт	544,891.40	551,573.32
210303	Цэвэр, бохир ус	3,414.90	2,474.90
2104	Хангамж, бараа материалын зардал	19,306.00	19,304.65
210401	Бичиг хэрэг	3,823.10	3,822.16
210402	Тээвэр, шатахуун	12,398.20	12,398.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,084.70	3,084.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,501.00	31,452.83
210604	Урсгал засвар	31,501.00	31,452.83
2107	Томилолт, зочны зардал	5,109.30	5,042.90
210702	Дотоод албан томилолт	5,109.30	5,042.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,828.00	4,776.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,700.00	3,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	459.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	217.40
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73.80	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	203.00
210807	Газрын төлбөр	138.30	123.10
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	247,740.80	232,333.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	243,930.70	228,555.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,810.10	3,778.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,187.00	83,187.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,187.00	83,187.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,900.00	48,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,287.00	34,287.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	367,993.50	321,290.21
223001	Бусад хөрөнгө	367,993.50	321,290.21
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.00	589.20
230001	Эргэж төлөгдөх зээл	70,000.00	589.20
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,128,638.50	1,920,825.58
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,741,582.40	1,895,478.71
320001	Орон нутгийн төсвөөс	1,435,379.30	1,601,891.21
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	306,203.10	293,587.50
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	387,056.10	25,346.87
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	25,346.87
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	387,056.10	0.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	134,921.13
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	140,948.59
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	48	48
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23
620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	Үйлчлэх ажилтан	2	2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,582.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,582.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,555.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,748.00
210101	Үндсэн цалин	3,748.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,127.20
210402	Тээвэр, шатахуун	3,127.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	425.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	425.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,255.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,255.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,026.78
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,026.78
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,026.78
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,582.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,582.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,982.73

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сонгино сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, үндсэн үүргээ мөрдлөг болгон, УИХ, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлагуудаас гаргасан тогтоол шийдвэр, заавар журам, албан даалгаврыг

хэрэгжүүлэх, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хийж хэрэгжүүлэхээр зорилтуудыг биелүүлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 5 бүлэг 15 зорилтын хүрээнд 68 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 87.5 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сонгино сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сонгино сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 450,413.81 мянган төгрөгөөр буюу 23.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	669,809.65	738,960.14	69,150.49
Авлага	130,734.44	105,368.09	(25,366.35)
Бараа материал	169,161.45	192,952.53	23,791.08
Үндсэн хөрөнгө	967,563.80	1,350,402.39	382,838.60
Нийт хөрөнгө	1,937,269.34	2,387,683.15	450,413.81
Өр төлбөр	9,488.22	7,000.00	(2,488.22)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,927,781.12	2,380,683.15	452,902.03
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,937,269.34	2,387,683.15	450,413.81

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 738,960.14 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,150.49 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг	669,809.65	738,960.14	69,150.49
Төрийн сангийн харилцах	669,809.65	738,960.14	69,150.49
Дүн	669,809.65	738,960.14	69,150.49

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 69,150.49 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн, ОНХС-ийн зарим ажил хийгдээгүйгээс үлдэгдэл өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 105,368.09 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,366.35 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	19.48	0.00	(19.48)
Хувь хүмүүсээс авах авлага	130,714.96	105,368.09	(25,346.87)
Дүн	130,734.44	105,368.09	(25,366.35)

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 25,366.35 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага барагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 241,669.36 мянган төгрөг болж, өмнөх оноос 57,685.25 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	154,551.45	177,102.53	22,551.08
Бичиг хэргийн материал	1,569.15	1,636.35	67.20
Аж ахуйн материал	1,913.36	17,020.50	15,107.14
Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00	0.00
Түлш, шатах тослох материал	0.00	0.00	0.00
Барилгын засварын материал	90.00	0.00	(90.00)
Бусад хангамжийн материал	150,978.95	158,445.68	7,466.73
Мал амьтад	14,610.00	15,850.00	1,240.00
Дүн	169,161.45	192,952.53	23,791.08

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 23,791.08 мянган төгрөгөөр өссөн нь Тайлант онд 226,938.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 12,491.0 мянган төгрөгийг

аж ахуйн материалыг данс бүртгэлд тусгасан, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 34,754.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 250,393.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой зөрчил илрээгүй байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,098,473.31 мянган төгрөг болж, өмнөх оноос 558,272.28 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	952,701.80	1,322,002.39	369,300.60
Барилга, байгууламж, орон сууц	483,029.27	642,146.95	159,117.68
Авто-тээврийн хэрэгсэл	147,000.00	298,523.51	151,523.51
Машин тоног төхөөрөмж(компьютер)	394,435.56	406,286.42	11,850.86
Тавилга, аж ахуйн эд хогшил	35,689.62	37,038.00	1,348.38
Бусад үндсэн хөрөнгө	549,426.82	478,024.59	(71,402.24)
Биет бус хөрөнгө	36,468.00	94,491.20	58,023.20
Программ хангамж	8,350.00	8,350.00	0.00
Бусад биет бус хөрөнгө	10,262.00	26,020.00	15,758.00
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	-660,629.48	-545,987.07	114,642.41
Дүн	967,563.80	1,350,402.39	382,838.60

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 382,838.60 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 14,500.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 197,830.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, бусад байгууллагаас 332,368.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, тайлант оны элэгдлийн зардалд 114,642.41 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,488.22 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст төлөх өглөг			
Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,488.22	7,000.00	(2,488.22)
Дүн	9,488.22	7,000.00	(2,488.22)

Өр төлбөр өмнөх оны үлдэгдлээс 7,000.00 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүст төлөх өглөг 9,488.22 мянган төгрөг барагдсан барагдсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөртэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,380,683.15 мянган төгрөг болж, өмнөх оноос 452,902.03 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	390,906.26	390,906.26	
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	390,906.26	390,906.26	
Хуримтлагдсан үр дүн	1,251,841.00	1,704,743.04	452,902.03
Өмнөх үеийн үр дүн	1,093,814.07	1,251,841.00	158,026.94
Тайлант үеийн үр дүн	158,026.94	452,902.03	294,875.09
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	285,033.86	285,033.86	-
Дүн	1,927,781.12	2,380,683.15	452,902.03

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 452,902.03 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 14/05 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 2,054,928.0 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,617,098.2 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 642,521.4 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 306,203.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 437,829.8 мянган төгрөгийг Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс, 281,317.6 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 70,000.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс, 317,056.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2024 оны Татварын болон татварын бус орлогыг 129,167.4 мянган төгрөгөөр, 36,510.5 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс олгох Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардлыг 73,487.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2024 оны 11 сарын 4-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 97,401.1 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 500,756.9 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 293,587.5 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 96,330.8 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 829,558.4 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 387,086.45 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 111,865.7 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 74,406.00 мянган төгрөгөөр дутуу олгогдсон,

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	500,756.9	500,756.9	0.00
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	367,993.5	293,587.5	-74,406.00
3	Татварын болон татварын бус орлого	410,485.0	410,485.0	0.00
4	Урьд оны үлдэгдэл	268,085.7	275,279.1	7,193.40
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	70,000.00	25,346.8	-44,653.20
6	Улсын төсвийн байгууллагын тогтмол зардал	511,317.4	511,317.4	
ДҮН		2,128,638.5	2,016,772.8	-111,865.7

Татварын болон татварын бус орлогоор 849,241.3 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 19,682.9 мянган төгрөгийг, санхүүжилтэд 410,485.0 мянган төгрөгийг олгож, 419,073.4 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,914,797.8 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь Засаг даргын нөөц хөрөнгийг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүй зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	150,431.80	148,950.70	1,481.10	99.02
2	Засаг даргын Тамгын газар	1,028,895.80	935,526.50	93,369.30	90.93
3	Орон нутгийн хөгжлийн сан	367,993.50	321,290.20	46,703.30	87.31
4	Хоршоо хөгжүүлэх сан	70,000.00	589.2	69,410.80	0.84
5	Улсын төсвийн байгууллагын тогтмол зардал	511,317.40	508,441.20	2,876.20	99.44
ДҮН		2,128,638.5	1,914,797.80	213,840.70	89.95

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2024 онд нэмэлт санхүүжилтээр 50,582.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 43,556.0 мянган төгрөгийг үндсэн цалин, тээвэр шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үечилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, үлдэгдэл 7,026.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу

Сонгино сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Алтансүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сонгино сумын Засаг дарга нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 11 -ны өдөр 1/46 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,268,574.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 49,028.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 36,771.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 21 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Сонгино сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	104,947.1	1	104,947.1	100%
Хариуцлага тооцох албан шаардлага	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт илрүүлсэн 177,160.1 мянган төгрөгийн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 128,131.5 мянган төгрөгөөр их, "Хязгаарлалтай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага: Харьяалагдах төсвийн шууд захирагчийн санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас морины гарааны болон сэрвээ хэмжих төхөөрөмж худалдаж авч, сумын 100 жилийн ойн хүрээнд "Эвэнт" арга хэмжээ, сургалт зохион байгуулж батлагдсан төсвөөс 26,500.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд спортын тэмцээн, спортын бага наадам, залуучууд, эмэгтэйчүүдийн уулзалт, эрдэм шинжилгээний бага хурал, урлаг соёлын арга хэмжээний зардал, ойн энгэрийн тэмдэг, хүндэт тэмдэг, 100 жилийн ойн ном сэтгүүлийн үнэ зэрэгт 83,000.0 мянган төгрөгийг зарцуулсан, Аймгийн ОНХС-аас эрх шилжсэн хөрөнгөөс сумын 100 жилийн арга хэмжээний нээлт, хаалт дамжуулах телевизийн 19,850.0 мянган төгрөгийг зарцуулсан, Хоршоо хөгжүүлэх сангаас санхүүгийн дэмжлэг авч гэрээт хугацаандаа зээлээ төлөөгүй зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, зээлдэгчийн зээлийн материалыг шүүхэд шилжүүлээгүй, шүүхээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлээгүй зээлдэгчийн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн шийдвэрлүүлээгүй 12 иргэний 49,756.100 мянган төгрөгийн эргэн төлөгдөөгүй зээл зэрэг нийт 177,106.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
ЗДТГ, ХС-ын үйл ажиллагаад хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	177,106.1			1	177,106.1							
Дүн	1	177,106.1			1	177,106.1							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ

Огноо: 2025-03-25
ATA6366 9039376
0921100009

Огноо: 2025-03-25

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

О.АЛТАНСУВД